

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР

ДОТООД АУДИТ ХИЙГДСЭН БАЙГУУЛЛАГА: ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН АЛБАН ХААГЧДЫН ЦАЛИН ТОГТООЛТ, БОДОЛТ, ОЛГОЛТ, НИЙГМИЙН ДААТГАЛ ШИМТГЭЛ, ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН НОГДУУЛАЛТ

ДОТООД АУДИТЫН НЭГЖ: ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

- ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН –
АБ4000

ДОТООД АУДИТЫН НЭР: ТӨЛӨВЛӨГӨӨТ БУС ДОТООД АУДИТ

ДОТООД АУДИТАД ХАМРАГДАХ ХУГАЦАА: 2024 ОН, 2025 ОНЫ I, II, III УЛИРАЛ

Улаанбаатар хот

2025 он

АУДИТ ХИЙСЭН БАЙГУУЛЛАГА: ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

АУДИТ ХИЙГДСЭН БАЙГУУЛЛАГА: ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН АЛБАН ХААГЧДЫН ЦАЛИН ТОГТООЛТ, БОДОЛТ, ОЛГОЛТ, НИЙГМИЙН ДААТГАЛ ШИМТГЭЛ, ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН НОГДУУЛАЛТ

АУДИТЫН ТӨРӨЛ: ТӨЛӨВЛӨГӨӨТ БУС ДОТООД АУДИТ

АУДИТЫН ХУГАЦАА: 2025.10.13-11.11

ДОТООД АУДИТЫН НЭГЖИЙН ДАРГА: ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Х.ОЮУНБИЛЭГ

АУДИТЫН БАГИЙН ГИШҮҮН: ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТСИЙН ДОТООД АУДИТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Б.БААСАНСҮРЭН, С.НАРАНЧИМЭГ

АГУУЛГА

1.	ТАНИЛЦУУЛГА	5
2.	АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ	5
2.1.	ДОТООД АУДИТЫН ЗОРИЛГО.....	5
2.2.	ДОТООД АУДИТЫН ХАМРАХ ХҮРЭЭ, ХЯЗГААРЛАЛТ	5
2.3	ДОТООД АУДИТЫН АРГА, АРГАЧЛАЛ	5
2.4	СУДАЛГАА	5
3.	АУДИТЫН ҮР ДҮН, АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДЛУУД.....	6
4.	НЭГДСЭН ДҮГНЭЛТ	13
5.	ЗӨВЛӨМЖ.....	14

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

МУ	Монгол Улс
ЦУОШГ	Цаг уур, орчны шинжилгээний газар
ХШДАХ	Хяналт, шинжилгээ дотоод аудитын хэлтэс
СХОХ	Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс

ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛ

1. ТАНИЛЦУУЛГА

Дотоод аудитын танилцуулга:

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6-д заасан дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, Засгийн газрын 2015 оны 483 дугаар “Дүрэм батлах тухай” тогтоолыг тус тус үндэслэн Цаг уур, орчны шинжилгээний газар цаашид ЦУОШГ-ын албан хаагчдын цалин тогтоолт, бодолт, олголт, нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварын ногдуулалтад төлөвлөгөөт бус дотоод аудит хийв.

Дотоод аудитыг Хяналт, шинжилгээ дотоод аудитын хэлтэс цаашид ХШДАХ-ийн дарга Х.Оюунбилэг ахалж, ахлан мэргэжилтэн Б.Баасансүрэн, С.Наранчимэг нар 2025 оны 10 дугаар сарын 13-ны өдрөөс ажлын 11 дүгээр сарын 11-ны өдрийн хооронд гүйцэтгэв.

Дотоод аудитаар 2024 он, 2025 оны I, II, III улирлын ЦУОШГ-ын албан хаагчдын цалин тогтоолт, бодолт, олголт, нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварын ногдуулалтыг Төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль болон тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журамд нийцсэн эсэхийг үнэлж, тайлант хугацаанд илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, засаж залруулахаар холбогдох ажилтнуудад танилцуулан, зөвлөмж өгч ажиллав.

2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ

2.1. Дотоод аудитын зорилго

ЦУОШГ-ын албан хаагчдын цалин тогтоолт, бодолт, олголт, нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварын ногдуулалтад дотоод аудит хийж, үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөгөө өгөх замаар ажлын үр дүнг нэмэгдүүлэхэд оршино.

2.2. Дотоод аудитын хамрах хүрээ, хязгаарлалт

Дотоод аудитын хамрах хүрээ:

- 2024 он, 2025 оны I, II, III улирлын ЦУОШГ-ын цалин хөлс тогтоолт, тооцоолол, олголт;
- ЦУОШГ-ын бүтэц орон тоо баталсан тушаал, шийдвэр;
- ЦУОШГ-ын гаргасан тушаал, шийдвэр;
- Ажилчдын цагийн бүртгэл, цаг ашиглалтын тайлан;
- Албан хаагчдын судалгаа, бусад;

2.3 Дотоод аудитын арга, аргачлал

Цалин хөлс тогтоолт, тооцоолол, олголтыг анхан шатны баримт, тайлан, гүйлгээний төлбөрийн хүсэлттэй тулган баталгаажуулах, тооцооллыг давтан шалгах, холбогдох албан хаагчтай ярилцлага хийх, лавлагаа, тодруулга авах, биет тест хэрэгжүүлэх зэрэг аудитын горимын дагуу нотлох баримт цуглуулан гүйцэтгэж, дүгнэлт, зөвлөмжийг боловсрууллаа.

2.4 Судалгаа

Хөдөлмөрийн тухай хууль, байгууллагын дотоод журмын дагуу алба хаагчдын илүү цагаар ажилласан хөлсийг олгосон эсэх, 2024-2025 оны байдлаар илүү цагаар ажилласан алба хаагчдын илүү цагаар ажилласан нэмэгдлийг олгосон эсэх, илүү цагаар ажилласан шалтгааныг тодруулах зорилгоор дараах 4 асуулт бүхий судалгааг хийлээ.

АУДИТЫН ҮР ДҮН, АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДЛУУД

Илэрсэн асуудал 1	Ажил хавсран, түр орлон гүйцэтгэсэн нэмэгдлийг Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ алба хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам”-ыг ижил тэгш хэрэгжүүлдэггүй байна.
Бодит нөхцөл байдал: Дараах албан хаагчдад нэмэгдэл цалинг олгох тушаал, шийдвэр ижил тэгш гараагүй байна. 1. Ахлах нягтлан бодогч Д.Отгонбаярт 2023 оны 11 дүгээр сарын 01-ны өдрийн Б/107 дугаар тушаалаар Хөрөнгө оруулалт, өмч ашиглалт хариуцсан мэргэжилтний албан үүргийг түр орлон гүйцэтгүүлсэн өдрөөс эхэлж ТЗ-7 ангиллын сарын үндсэн цалингийн 40 хувиар нэмэгдэл олгосон. 2. Орчны шинжилгээний салбарын хөтөлбөрийн хэрэгжилт, технологи хариуцсан ахлах мэргэжилтэн С.Энхмаад 2024 оны 04 дүгээр сарын 19-ны өдрийн Б/48 дугаар тушаалаар Орчны шинжилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэхдээ цалингийн зөрүүг 9 сарын хугацаанд буюу 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл олгож, 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/06 дугаар “Газрын албан хаагчдын үндсэн цалин хөлсийг шинэчлэн батлах тухай” тушаалын хавсралтад ТЗ-6 ангиллын албан тушаалын үндсэн цалингаас 40 хувийн нэмэгдлийг олгосон. 3. Мэргэжилтэн Э.Баттүшигт 2020 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн Б/01 дүгээр тушаалаар хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтны ажлыг хавсран гүйцэтгүүлэх нэмэгдэл цалинг үндсэн цалингийн 30 хувиар тооцож олгох тушаалын шийдвэрийг 20 хувиар тооцож бууруулахдаа албан хаагчид өөрт нь хамаарах Б тушаал гаргаагүй. 4. Касс, эд ахуйн нярав О.Оюунцэцэгт 2017 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн “Ажлаас чөлөөлөх, ажилд томилах, ажил хавсран гүйцэтгэх тухай” Б/75 дугаар тушаалаар Төвлөрсөн хангамжийн нярав ТҮ-4 ангиллын албан тушаалын үндсэн цалингийн 40 хувиар нэмэгдлийг олгох тушаал гарсан. Газрын даргын 2019 оны баталсан “Албан тушаал, түүний ангилал зэрэглэлийг шинэчлэн батлах тухай” А/334 дүгээр тушаалаар Төвлөрсөн хангамжийн няравын ТҮ-4 ангиллын албан тушаал байхгүй болж, Төвлөрсөн хангалтын асуудал хариуцсан мэргэжилтэн ТҮ-7 ангилал зэрэглэл өөрчлөлдсөн байхад О.Оюунцэцэгт тухайн ТҮ-7 ангиллын албан тушаалын ажлыг хавсран гүйцэтгүүлэх захиргааны шийдвэр гараагүй байхад 2017 оны 06 дугаар сарын 15-аас 2025 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн хүртэл 40 хувиар нэмэгдлийг олгосон ба төвлөрсөн хангалтын асуудал хариуцсан мэргэжилтэн ТҮ-7 ангиллын албан тушаалын тодорхойлолт батлагдаагүй байна. 5. Санхүү, төлөвлөлт, хамтын ажиллагааны хэлтсийн дарга Н.Галцогт 2023 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн Б/103 дугаар тушаалаар Захиргаа, аудитын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэхдээ нэмэгдэл цалин олгоогүй. 6. Архив, мэдээллийн сангийн удирдлагын системийн ерөнхий инженер М.Хишигжаргалд 2024 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн Б/22 дугаар тушаалаар Мэдээллийн сан хариуцсан ахлах мэргэжилтний албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэхдээ 11 дүгээр сарын 01-ны өдрийг хүртэл 10 сарын хугацаанд цалингийн зөрүү олгосон, 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн Б/109 дүгээр тушаалаар өөрийнх нь албан тушаалын үндсэн цалин болох ТҮМ-7 ангиллын цалингийн 25%-иар нэмэгдэл олгосон байна.	
Шалгуур үзүүлэлт: -Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ алба хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам”	
Асуудлын үндсэн шалтгаан: -Удирдлагын буруутай шийдвэр гаргалт;	

-Санхүү болон хүний нөөцийн асуудал хариуцсан албан хаагч удирдлагыг мэдээллээр хангаж ажиллаагүйгээс.

Үзүүлэх нөлөө /үр дагавар/:

-Өр, авлага үүсгэхгүй байх зарчим алдагдах;

-Төсөв санхүүгийн эрсдэл учрах (*Аудит, хяналт шалгалтын байгууллагаар төлбөрийн акт тогтоогдох*).

Зөвлөмж:

-Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн жинхэнэ алба хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам"-ыг хэрэгжүүлэхдээ албан хаагчдад ижил тэгш баримталж ажиллах;

-Сул орон тооны албан үүрэг гүйцэтгэсний цалин, цалингийн зөрүүг тухай бүрд зөв тооцож, Төсвийн тухай хуульд нийцүүлэн төсвийн жилд нь олгох;

-ТҮ, ТҮМ ангиллын албан тушаалын сул орон тоонд түр орлох, ажил хавсран гүйцэтгүүлэх зохицуулалтыг хөдөлмөрийн дотоод журамд тусгаж, нэмэгдлийн хувийг ялгаатай байдлаар олгох шийдвэр гаргахгүй байх.

Илэрсэн асуудал 2	Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журмыг баримталдаггүй, шөнийн цагийн нэмэгдэл хөлсийг дутуу олгосон.
--------------------------	---

Бодит нөхцөл байдал:

Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.3. Шөнийн цагаар ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол түүний дундаж цалин хөлсийг нэг аравны хоёр дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлж олгоно, 109.8. Ажилтныг ээлжийн хуваарийн дагуу шөнийн цагт ажиллуулбал шөнийн цагийн нэмэгдэл хөлсийг нэмж олгоно.

-Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын 2.3. "шөнийн цагаар ажилласан төрийн албан хаагчийг нөхөн амруулаагүй бол түүний дундаж цалин хөлсийг нэг аравны хоёр (нэг аравны хоёроос дээш байхыг хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээнд тусган зохицуулж болно.) дахин нэмэгдүүлэн тооцно", 2.5. "албан хаагчийг ээлжийн хуваарийн дагуу шөнийн цагт ажиллуулбал шөнийн цагийн нэмэгдэл хөлсийг олгоно. Ээлжээр ажилладаг албан хаагчийн ээлж долоо хоногийн амралтын болон нийтээр амрах баярын өдөр таарсан бол долоо хоногийн амралтын болон нийтээр амрах баярын өдрөөр ажилласны нэмэгдэл хөлс олгохгүй" заалтыг баримталж ажиллагүй байна.

1. 2024 он, 2025 оны I, II, III улиралд ээлжийн хуваарийн дагуу ажилдаг 22 албан хаагчийн шөнийн цагийн нэмэгдлийг 1.2 дахин нэмэгдүүлж олгоогүй байна. ЦУОШГ-ын даргын 2018 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн "Шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс олгох тухай" А/25 дугаар тушаалаар шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлсийг 0.5 хувиар тооцож олгох тушаалыг үндэслэж олгосон гэх СХОХ-ын дарга, Ерөнхий нягтлан бодогч, тооцооны нягтлан бодогч нарын тайлбар ирсэн боловч Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.3.Шөнийн цагаар ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол түүний дундаж цалин хөлсийг нэг аравны хоёр дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлж олгоно, 109.8.Ажилтныг ээлжийн хуваарийн дагуу шөнийн цагт ажиллуулбал шөнийн цагийн нэмэгдэл хөлсийг нэмж олгоно гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, ЦУОШГ-ын даргын шийдвэргүйгээр шөнийн цагийн нэмэгдлэл хөлсийг тооцож олгохдоо дундаж цалин хөлсийг 0.3 хувиар тооцож цалин дутуу олгосон байна. Үүнд:

2024 онд

№	Овог	Нэр	Ажилласан өдөр	Ажилласан цаг	Дутуу тооцсон цалин
1	Болд	Алтансувд	236	1,888	262,990

2	Даржаа	Амарцэцэг	225	1,800	1,116,910
3	Нямсамбуу	Анхзаяа	214	1,712	574,616
4	Даш	Батбаяр	203	1,624	1,793,889
5	Санжаабаатар	Батбаяр	163	1304	2,145,176
6	Анз	Ганзориг	182	1,456	1,619,817
7	Сэрээнэндорж	Жавзмаа	44	352	84,629
8	Дэлгэрсайхан	Лхагвасүрэн	231	1,848	682,975
9	Мөнхтогтох	Мөнх-эрдэнэ	236	1,888	284,509
10	Энхбаатар	Мөнх-эрдэнэ	179	1,432	1,142,341
10	Батдаваа	Нямцэцэг	236	1,888	56,006
12	Чулуунбат	Оюунгэрэл	225	1,800	709,160
13	Оюун	Өнөртуул	218	1,744	874,238
14	Толя	Төмөрсүх	185	1,480	945,277
15	Болдсайхан	Цасанчимэг	231	1,848	1,368,502
16	Батболд	Цогтбаатар	231	1,848	1,946,949
17	Эрдэнэбаатар	Цэнд-Аюуш	223	1,784	511,102
18	Одгэрэл	Эрдэнэтуяа	228	1,824	943,603
Нийт					17,062,689

2025 онд

№	Овог	Нэр	Ажилласан өдөр	Ажилласан цаг	Дутуу тооцсон цалин
1	Болд	Алтансүвд	27	216	819,747
2	Даржаа	Амарцэцэг	137	1,096	1,790,706
3	Нямсамбуу	Анхзаяа	97	776	530,020
4	Даш	Батбаяр	163	1,304	2,348,784
5	Санжаабаатар	Батбаяр	139	1,112	1,691,260
6	Анз	Ганзориг	163	1,304	2,257,437
7	Сэрээнэндорж	Жавзмаа	44	352	1,385,642
8	Дэлгэрсайхан	Лхагвасүрэн	168	1,344	991,035
9	Мөнхтогтох	Мөнх-эрдэнэ	117	936	503,765
10	Энхбаатар	Мөнх-эрдэнэ	82	656	175,060
11	Мөнхтуяа	Нарангэрэл	45	360	400,364
12	Батдаваа	Нямцэцэг	189	1,512	1,138,000
13	Чулуунбат	Оюунгэрэл	96	768	564,683
14	Оюун	Өнөртуул	167	1,336	1,716,473
15	Мөнхтөр	Солонгоо	127	1,016	1,465,035
16	Толя	Төмөрсүх	126	1,008	1,651,658
17	Болдсайхан	Цасанчимэг	167	1,336	3,112,390
18	Батболд	Цогтбаатар	169	1,352	2,611,639
19	Вандансүрэн	Цогтсайхан	169	1,352	261,298
20	Цэвээнжав	Цолмон	174	1,392	1,154,651
21	Эрдэнэбаатар	Цэнд-Аюуш	171	1,368	1,960,157
22	Одгэрэл	Эрдэнэтуяа	171	1,368	2,101,920
Нийт					30,631,733

2. Батлагдсан нийт цалин хөлсний төсвийг сар бүрийн гүйцэтгэлийг шөнийн цагийн нэмэгдэл хөлс дутуу олгосон байдалтай харьцуулан үзэхэд нэмэгдэл цалин цалинг дутуу олгох үндэслэлгүй байна.

2024 он

Он сар	Нийт цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал (хэмнэлт өссөн дүнгээр)	Нэмэгдэл цалин хөлс (хэмнэлт өссөн дүнгээр)	Шөнийн цагийн нэмэгдэл цалин дутуу тооцсон дүн
2024.01	72,213,299	62,109,389	1,761,967
2024.02	149,297,259	127,858,186	1,558,152
2024.03	224,263,681	38,968,964	1,109,271
2024.04	313,195,615	235,998,517	1,299,095
2024.05	313,195,615	235,998,517	728,382
2024.06	420,654,383	342,227,412	738,852
2024.07	420,654,383	342,227,412	1,547,030

2024.08	607,173,103	511,033,945	2,641,540
2024.09	607,173,103	511,033,945	1,092,473
2024.10	767,739,568	540,050,567	1,285,645
2024.11	744,979,399	514,921,092	867,226
2024.12	272,652,100	86,064,433	2,433,055
Нийт	272,652,100	86,064,433	17,062,689

<https://shilendans.gov.mn/organization/11554?ry=2024&group=117>

2025 он

Он сар	Нийт цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал (хэмнэлт өссөн дүнгээр)	Нэмэгдэл цалин хөлс (хэмнэлт өссөн дүнгээр)	Нэмэгдэл цалин дутуу тооцсон дүн
2025.01	55,032,223	39,278,244	5,764,832
2025.02	89,759,466	93,350,013	5,354,477
2025.03	169,515,163	97,596,453	4,678,037
2025.04	145,366,673	99,157,796	3,257,863
2025.05	32	49	1,854,521
2025.06	10,675,369	6,756,831	1,200,970
2025.07	9,120,750	23,812,080	1,352,391
2025.08	52,050,546	59,745,950	3,341,840
2025.09	78,656,069	102,502,648	3,826,803
Нийт	78,656,069	102,502,648	30,631,733

<https://shilendans.gov.mn/organization/11554?ry=2025&group=117>

Шалгуур үзүүлэлт

-Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”;

-Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.3-т “шөнийн цагаар ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол түүний дундаж цалин хөлсийг нэг аравны хоёр дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлж олгоно”, 109.8-д Ажилтныг ээлжийн хуваарийн дагуу шөнийн цагт ажиллуулбал шөнийн цагийн нэмэгдэл хөлсийг нэмж олгоно”;

-Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”-ын 2.3. “шөнийн цагаар ажилласан төрийн албан хаагчийг нөхөн амруулаагүй бол түүний дундаж цалин хөлсийг нэг аравны хоёр (нэг аравны хоёроос дээш байхыг хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээнд тусган зохицуулж болно.) дахин нэмэгдүүлэн тооцно”, 2.5. “албан хаагчийг ээлжийн хуваарийн дагуу шөнийн цагт ажиллуулбал шөнийн цагийн нэмэгдэл хөлсийг олгоно. Ээлжээр ажилладаг албан хаагчийн ээлж долоо хоногийн амралтын болон нийтээр амрах баярын өдөр таарсан бол долоо хоногийн амралтын болон нийтээр амрах баярын өдрөөр ажилласны нэмэгдэл хөлс олгохгүй”.

Асуудлын үндсэн шалтгаан:

-Нэгжийн даргын хяналтгүй байдал;

-Ерөнхий болон тооцооны нягтлан бодогчийн ур чадвар, ажлын хариуцлагагүй байдал;

-Удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангаж ажиллаагүйгээс;

Үзүүлэх нөлөө /үр дагавар/:

-Албан хаагчдад ялгаатай байдлыг бий болгох;

-Эмх цэгцгүй байдал үүсэх;

-Хариуцлагын тогтолцоо алдагдах;

Зөвлөмж:

-Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.3, 109.8 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”-ыг хэрэгжүүлж ажиллах, алдаа дутагдал гаргасан албан хаагчдад хариуцлага тооцож, 2025 оны дутуу олгосон цалин хөлсийг нөхөж олгох

-Хууль, дүрэм журмын өөрчлөлтийг тухай бүр хэрэгжүүлж ажиллах;

-Удирдлагыг үнэн зөв, бодитой мэдээллээр хангаж ажиллах;

Илэрсэн асуудал 3	Төрийн үйлчилгээний албан хаагчийн ур чадварын нэмэгдлийг батлагдсан шалгуур үзүүлэлтээр үнэлж, дүгнэлгүйгээр олгосон байна.
Бодит нөхцөл байдал: ЦУОШГ-т 2025 оны 09 дүгээр сарын нийт 38 ажилтан, албан хаагч ТҮМ, ТҮ, ТҮМТ төрийн үйлчилгээ ангиллаар буюу хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байна. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2023 оны А/421, А/115, А/170 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт, хэрэглэх журам”-ын 8-д заасны дагуу “Байгууллагын дарга, захирлаас бусад албан хаагчдын Ур чадварыг үнэлж, дүгнэх, нэмэгдлийн хэмжээг тогтоох, нэмэгдэл олгох асуудлыг тухайн байгууллагын удирдах ажилтны шийдвэрээр байгуулсан ажлын хэсгийн санал дүгнэлтийг үндэслэн холбогдох төсвийн захирагч шийдвэрлэнэ”, 10-д “Ур чадварыг үнэлж дүгнэх, нэмэгдэл олгох үйл ажиллагаа нь ил тод нээлттэй, шударга, хамтын оролцоог хангасан, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх заалтыг мөрдөж ажиллаагүй буюу ТҮМ, ТҮ, ТҮМТ төрийн үйлчилгээний албан хаагчдад 2024 оны 01 дүгээр сараас 2025 оны 08 дугаар сар хүртэл 10-25 хувийн ур чадварын нэмэгдэл олгохоор шийдвэрлэсэн ажлын хэсгийн тушаал, нэмэгдэл олгох үйл ажиллагаа нь ил тод нээлттэй, шударга, хамтын оролцоог хангасан хурлын тэмдэглэлгүй байна.	
Шалгуур үзүүлэлт: -Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” - Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2023 оны А/421, А/115, А/170 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт, хэрэглэх журам”	
Асуудлын үндсэн шалтгаан: -Хүний нөөцийн ажилтан удирдлагыг мэдээллээр хангаж ажиллаагүйгээс;	
Үзүүлэх нөлөө /үр дагавар/: -Албан хаагчдад ялгаатай байдлыг бий болгох; -Ажлын чиг үүрэг давхардах эсхүл гээгдэх, орхигдох; -Албан хаагчдын ажлын байрны сэтгэл ханамжийн байдалд сөргөөр нөлөөлөх -Хариуцлагын тогтолцоо алдагдах;	
Зөвлөмж: - Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2023 оны А/421, А/115, А/170 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт, хэрэглэх журам”-ыг хэрэгжүүлж ажиллах.	
Илэрсэн асуудал 4	1. Мэргэшлийн зэргийн нэмэгдлийг тушаал гарсан сараас олгоогүй; 2. Төрийн болон албаны нууц хамгаалах ажилтны албан үүргийг хавсран гүйцэтгүүлж, хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг олгохдоо тал хувиар олгосон.
Бодит нөхцөл байдал: 1. ЦУОШГ-ын даргын 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн “Хүрэлбаатарын Туулцэцэгт мэргэшлийн зэрэг олгох тухай” Б/12 дугаар тушаалаар Байгууллагын архив	

хариуцсан мэргэжилтэн Х.Туулцэцэгт ахлах зэрэг олгож, нэмэгдлийг 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн албан тушаалын цалингийн 10 хувиар тооцож олгохоор заасан зэргийн нэмэгдлийг 4 сарын олгоогүй буюу 2025 онд **нийт 565,600 төгрөг** дутуу олгосон байна.

2. ЦУОШГ-ын даргын 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн “Дашдэмбэрэлийн Уянгаад төрийн болон албаны нууц хамгаалах ажилтны албан үүргийг хавсран гүйцэтгүүлэх тухай” Б/87 дугаар тушаалаар Бичиг хэрэг, дотоод асуудал харицсан мэргэжилтэн Д.Уянгаад 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн төрийн болон албаны нууц хамгаалах ажилтны албан үүргийг хавсран гүйцэтгүүлж, хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг албан тушаалын үндсэн цалингийн 10 хувиар тооцож олгохоор заасан байхад 2024 оны 03 сараас 2025 оны 02 дугаар сар дуустал хугацаанд 5% олгосон буюу **2024 онд 660,464 төгрөг, 2025 онд 147,827 төгрөг** тус тус дутуу олгосон байна.

Шалгуур үзүүлэлт:

-Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”

Асуудлын үндсэн шалтгаан:

-Нэгжийн даргын хяналтгүй байдал;

-Ерөнхий болон тооцооны нягтлан бодогчийн ур чадвар, ажлын хариуцлагагүй байдал;

Үзүүлэх нөлөө /үр дагавар/:

-Албан хаагчдад ялгаатай байдлыг бий болгох;

-Ажлын чиг үүрэг гээгдэх, орхигдох;

-Хариуцлагын тогтолцоо алдагдах;

Зөвлөмж:

-Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;

-Гарсан тушаалын хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах;

Илэрсэн асуудал 5

Мөнгөн шагналыг зардлын ангилал зөрчиж цалингийн зардлаас гаргасан.

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.3.төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах, Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал”-ын холбогдох ангилалд нийцэхгүй Газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн “Мөнгөн шагнал олгох тухай” А/361 дүгээр тушаалаар 21 албан хаагчдад нийт 22,539,595 төгрөгийн шагналыг цалингийн зардлаас олгосон ба үйл ажиллагаа нь ил тод нээлттэй, шударга, хамтын оролцоог хангасан хурлын тэмдэглэлгүй байна.

Шалгуур үзүүлэлт:

-Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”; 41 дүгээр зүйлийн 41.2.3.төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах; Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал”-ын холбогдох ангилал;

- Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 3.3. Мөнгөн шагналыг төрийн онцгой чухал буюу онц төвөгтэй албан даалгавар биелүүлсэн, төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн төрийн албан хаагчид олгож болно. Байгууллагын удирдлагын шийдвэрээр тухайн ажилтныг шагнах мөнгөн шагналын хэмжээ нь сарын үндсэн цалинг 1.5 дахин

нэмэгдүүлсэнтэй тэнцэх хүртэл хэмжээтэй байна, 2.5-д заасан “энэ журмын 2.4-т зааснаас бусад төрийн албан хаагчид үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн гэрээнд заасан ажил үүргийн биелэлт, ажлын гүйцэтгэлийн үр дүнг үндэслэн олгоно.

Асуудлын үндсэн шалтгаан:

-Нэгжийн даргын хяналтгүй байдал;

-Ерөнхий болон тооцооны нягтлан бодогчийн ур чадвар, ажлын хариуцлагагүй байдал;

Үзүүлэх нөлөө /үр дагавар/:

-Албан хаагчдад ялгаатай байдлыг бий болгох;

Зөвлөмж:

-Зардлын эдийн засгийн ангилал болон төсвийн гүйцэтгэлийг буруу илэрхийлсэн зөрчлийг дахин гаргахгүй байх;

-Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах;

Илэрсэн асуудал 6 | Илүү цаг ажилласны нэмэгдэл хөлсийг ижил тэгш олгодоггүй.

Бодит нөхцөл байдал:

Илүү цагаар ажилладаг эсэх, илүү цаг ажилласны нэмэгдэл хөлсийг олгодог эсэх судалгаа хийж үзэхэд ЦУОШГ-ын өдрийн цагаар ажилладаг 35 алба хаагч судалгаанд хамрагдсан. Судалгаанд хамрагдсан 35 албан хаагчдаас 2024 онд 6, 2025 оны 1-9 сард 4 алба хаагч тогтмол илүү цагаар ажилласан, 2024 онд 15, 2025 оны 1-9 сард 20 алба хаагч хааяа илүү цагаар ажилласан, илүү цагаар ажилласан шалтгаан ихэвчлэн удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх буюу бусад гэж хариулсан байна. Судалгаанд оролцогчдын 14.3 хувь нь илүү цагийн хөлсийг тогтмол авдаг, 28.5 хувь нь хааяа авдаг, 57.2 хувь нь авдаггүй гэж хариулснаас үзэхэд илүү цагийн нэмэгдэл хөлсийг бүх албан хаагчдад ижил тэгш байна.

№	Асуулт	Хариултын төрөл	Хариулсан хүний тоо
1	Та 2024 онд илүү цагаар ажилласан уу?	Тийм тогтмол	6
		Тийм/хааяа	15
		Илүү цагаар ажиллаагүй	5
		Мэдэхгүй/санахгүй байна	3
2	Та 2025 онд илүү цагаар ажилласан уу?	Тийм тогтмол	4
		Тийм/хааяа	20
		Илүү цагаар ажиллаагүй	7
		Мэдэхгүй/санахгүй байна	4
3	Илүү цагаар ажилласан шалтгаан аль нь вэ?	Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх	13
		Баяр, ёслолын үеэр хариуцлагатай жижүүр хийх	5
		Албан тушаалын чиг үүрэгт ажил ажлын цагт амждаггүй	6
		Бусад /товч тайлбар бичсэн/	19
4	Илүү цагийн нэмэгдэл хөлс авч байсан уу?	Тийм/тогтмол	5
		Тийм/ хааяа	10
		Үгүй	20
		Мэдэхгүй	0
5	Ажлын цаг ашиглалт, илүү цагийн нэмэгдэл хөлстэй холбоотой санал хүсэлт байна уу?	Санал бичсэн тоо	20

Ажлын цаг ашиглалт, илүү цагийн нэмэгдэл хөлстэй холбоотой санал хүсэлт байна уу? гэсэн асуултад дараах санал хүсэлт бичсэн:

- Ажлын цагийн уян хатан нөхцөлийг хангаж өгнө үү;
- Илүү цагийг нөхөж өгөх боломжгүй үед нөхөж амрах;
- Өмнө нь ажлын цаг хоцроход цалин хасдаг байсан, илүү ажиллахад нэмэгдэл өгдөггүй;
- Илүү цагт юу хийж буйг тогтоох, гэнэтийн тушаалаар илүү цаг өгөх;
- Зарим хүмүүсийн өрөөгөөр их хэсдэг, цаг ашиглалт муу;
- Бар кодтой сургалтад илүү цаг өгөхгүй ч төлөвлөгөөний мэдлэг чадвар дээшлүүлсэнд тооцох;
- Илүү цаг өгвөл сайн байна цалин хүрэлцэхгүй;
- Архив, мэдээллийн сангаас шуурхай гаргах мэдээг гаргах ажил ихтэй үед илүү цаг олгоно уу;
- Үйлчилгээний ажилчдын ажлын цагийг уян хатан болгож өгнө үү. Гадна талбайн цас, навч цэвэрлэхэд жижүүр, сантехник хүмүүсийг адил хамруулах;
- Үйлчлэгч орлон ажиллах үед нэмэгдлийг илүү цаг байдлаар олгох;
- Амралтын өдөр, ажлын бус цагаар ажиллах үед илүү цаг авмаар байна. Даргын ойрын хүрээний хүмүүс илүү цаг авдаг сураг байдаг. Архивын ерөнхий газар руу улиралд 1-2 удаа явдаг түгжрэл ихтэй ажлын цаг хүрэлцдэггүй.

Шалгуур үзүүлэлт:

- Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.1.Илүү цагаар ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол түүний дундаж цалин хөлсийг нэг аравны тав дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлж олгоно, 109.5. Ажилтныг илүү цагаар, долоо хоногийн амралтын болон нийтээр амрах баярын өдөр шөнийн цагт ажиллуулсан бол энэ хуулийн 109.1, 109.2, 109.4-т заасан нэмэгдэл хөлс дээр шөнийн цагийн нэмэгдэл хөлсийг нэмж олгоно;
- Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”-ын 2.1.Илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр ажилласан төрийн албан хаагчийг нөхөн амруулаагүй бол түүний дундаж цалин хөлсийг нэг аравны тав дахин (нэг аравны таваас дээш байхыг хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээнд тусган зохицуулж болно.) нэмэгдүүлэн тооцно; 3. Илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна.

Асуудлын үндсэн шалтгаан:

- Нягтлан бодогчид удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангаж ажиллаагүйгээс;

Үзүүлэх нөлөө /үр дагавар/:

- Албан хаагчдад ялгаатай байдлыг бий болгох;
- Хариуцлагын тогтолцоо алдагдах;

Зөвлөмж:

- Хөдөлмөрийн тухай хууль, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”-ыг баримтлан ажиллах;
- Хууль, дүрэм журмын өөрчлөлтийг тухай бүр хэрэгжүүлж ажиллах;
- Удирдлагыг үнэн зөв, бодитой мэдээллээр хангаж ажиллах;

3. НЭГДСЭН ДҮГНЭЛТ

ЦУОШГ-ын албан хаагчдын цалин тогтоолт, бодолт, олголт, нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварын ногдуулалтад дотоод аудит хийлээ. Дотоод аудитаар дараах алдаа, дутагдал, зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.3-т “шөнийн цагаар ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол түүний дундаж цалин хөлсийг нэг аравны хоёр дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлж олгоно”, 109.8-д “Ажилтныг ээлжийн хуваарийн дагуу шөнийн цагт ажиллуулбал шөнийн цагийн нэмэгдэл хөлсийг нэмж олгоно” заалтыг хэрэгжүүлээгүй, ЦУОШГ-ын даргын тушаал шийдвэргүйгээр шөнийн ээлжийн 22 албан хаагчдад шөнийн цагийн нэмэгдлэл хөлсийг тооцож олгохдоо албан тушаалын чиг үүрэгт тусгагдаагүй эрх мэдлээ хэтрүүлж дундаж цалин хөлсийг 0.3 хувиар тооцож шөнийн нэмэгдэл цалинг 2024 онд 17,062,689 төгрөг, 2025 онд 30,631,733 төгрөг дутуу олгосон байна.

2. Ажил хавсран, түр орлон гүйцэтгэсэн нэмэгдлийг Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ алба хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам”-ыг ижил тэгш олгодоггүй ба Ерөнхий нягтлан бодогчид албан үүргийг түр орлон гүйцэтгүүлсэн өдрөөс эхэлж тухайн түр орлон гүйцэтгэж буй албан тушаалын цалингийн шатлалын 40 хувийн нэмэгдэл олгосон бол бусад албан хаагчдад түр орлон гүйцэтгэсэн хугацаанд нэмэгдэл хувь олгохгүй байх, эсхүл цалингийн зөрүүг 6-10 сар олгосоны дараа албан хаагчын үндсэн цалингаас 20-40 хувь олгосон ялгаатай тушаал шийдвэр гаргаж, хэрэгжүүлсэн байна.

3. Байгууллагын архив хариуцсан мэргэжилтэн Х.Туулцэцэгт ахлах зэрэг олгож, нэмэгдлийг 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн албан тушаалын цалингийн 10 хувиар тооцож олгохоор тушаалд заасан зэргийн нэмэгдлийг 4 сарын олгоогүй буюу 2025 онд нийт 565,600 төгрөг дутуу олгосон, Бичиг хэрэг, дотоод асуудал харицсан мэргэжилтэн Д.Уянгаад төрийн болон албаны нууц хамгаалах ажилтны албан үүргийг хавсран гүйцэтгэсэн нэмэгдлийг албан тушаалын үндсэн цалингийн 10 хувиар тооцож олгохоор заасан нэмэгдлийг 2024 оны 03 сараас 2025 оны 02 дугаар сар дуустал хугацаанд 5% олгосон буюу 2024 онд 660,464 төгрөг, 2025 онд 147,827 төгрөг дутуу олгосон байна.

ЦУОШГ-ын албан хаагчдын цалин тогтоолт, бодолт, олголт, нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварын ногдуулалтын 2024 он, 2025 оны эхний 3 улирлын байдалд хийсэн дотоод аудитаар илэрсэн алдаа, дутагдлуудад үндэслэн “зарим хяналттай холбоотой алдаа зөрчил, асуудал илэрсэн” үед өгдөг **“САЙЖРУУЛАЛТ ХЭРЭГТЭЙ”** дүгнэлтийг өгч байна.

4. ЗӨВЛӨМЖ

Дотоод аудитаар илэрсэн алдаа, дутагдлыг цаашид давтан гаргахгүй байх дараах зөвлөмжийг өгч ажиллалаа. Үүнд:

1. Хөдөлмөрийн тухай хууль, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”-ыг баримтлан ажиллах;

2. Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн жинхэнэ алба хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам”-ыг хэрэгжүүлэхдээ албан хаагчдад ижил тэгш баримталж ажиллах;

3. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2023 оны А/421, А/115, А/170 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт, хэрэглэх журам”-ын 8-д заасны дагуу “Байгууллагын дарга, захирлаас бусад албан хаагчдын Ур чадварыг үнэлж, дүгнэх, нэмэгдлийн хэмжээг тогтоох, нэмэгдэл олгох асуудлыг тухайн байгууллагын удирдах ажилтны шийдвэрээр байгуулсан ажлын хэсгийн санал дүгнэлтийг үндэслэн холбогдох төсвийн захирагч шийдвэрлэнэ”, 10-д “Ур чадварыг үнэлж дүгнэх, нэмэгдэл олгох үйл ажиллагаа нь ил тод нээлттэй, шударга, хамтын оролцоог хангасан, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх заалтыг мөрдөж ажиллах;

4. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан журамд заасныг хэрэгжүүлж ажиллах, анхан шатны баримтыг нэгжийн даргад хянуулдаг байх;
5. Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай хуулиуд болон тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журамд үндэслэн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, цаг ашиглалтын журам, бусад холбогдох журмуудад өөрчлөлт оруулах, шинэчлэх ажлыг зохион байгуулах;
6. Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.3, 109.8 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ыг хэрэгжүүлж ажиллах, алдаа дутагдал гаргасан албан хаагчдад хариуцлага тооцож, 2025 оны дутуу олгосон цалин хөлсийг нөхөж олгох дотоод аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй байх, үүсэж болзошгүй төсөв, санхүүгийн эрсдэлийг тодорхойлох, дүгнэлт хийж, гарсан зөрчлийг таслан зогсоох арга хэмжээ авч ажиллах;
7. Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал"-ын холбогдох ангилал төсвийн гүйцэтгэлийг буруу илэрхийлсэн зөрчлийг дахин гаргахгүй байх;
8. Дотоод аудитаар илэрсэн алдаа дутагдлуудыг арилгах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор ХШДАХ-т ирүүлэх;
9. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

Хавсралт:.... хуудастай.

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГА

Э.БАТТУЛГА

2025 оны 11 дүгээр сарын 13

ТАНИЛЦСАН:
УРЬДЧИЛАН МЭДЭЭЛЭХ
ХЭЛТСИЙН ДАРГА

Л.ОЮУНЖАРГАЛ

2025 оны 11 дүгээр сарын 12

ЗАХИРГАА, ХҮНИЙ НӨӨЦИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Р.БАДМААДОРЖ

2025 оны 11 дүгээр сарын 12

САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Н.ГАЛЦОГ

2025 оны 11 дүгээр сарын 12


ЕРӨНХИЙ НЯГТЛАН
БОДОГЧ

Д.ОТГОНБАЯР

2025 оны 11 дүгээр сарын 18

Засгийн газрын 483 дүгээр тогтоол 2015 он
цаг уур, орчны шинжилгээний газрын дарга
хэрэгжүүлж ажиллах

ТООЦООНЫ
НЯГТЛАН БОДОГЧ



С.ЦЭРЭННАДМИД

2025 оны 11 дүгээр сарын ...

ЗАХИРГАА, ХҮНИЙ НӨӨЦИЙН
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



Ж.ЭНХЧИМЭГ

2025 оны 11 дүгээр сарын ..12

ХЯНАСАН:
ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ
ДОТООД АУДИТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА



Х.ОЮУНБИЛЭГ

2025 оны 11 дүгээр сарын ..12

ТАЙЛАН БИЧСЭН:
ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ
ДОТООД АУДИТЫН ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



Б.БААСАНСҮРЭН

2025 оны 11 дүгээр сарын .12

ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ
ДОТООД АУДИТЫН ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



С.НАРАНЧИМЭГ

2025 оны 11 дүгээр сарын .12